

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Г “Их барилга төсөл” ХХК-ийн зарим бондыг бүртгэлээс хасах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Их барилга төсөл” ХХК-ийн анхдагч зах зээл дээр нийтэд санал болгон гаргасан 56,000 ширхэг бондоос арилжигдаагүй үлдэж тусгаарлагдсан 30,000 ширхэг тусгаарлагдсан бондыг Үнэт цаасны бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны газар” /Э.Ганбат/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН